



**2024 ОНД БОЛОХ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
УЛС ТӨРИЙН НАМУУДЫН МӨРИЙН
ХӨТӨЛБӨРТ ТУСГАХ САНАЛ**

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Улаанбаатар хот
2024 оны 2 сарын 23-ны өдөр

ТАНИЛЦУУЛГА

“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл нь боловсролын чанарыг сайжруулах, санхүүжилтэд хяналт тавьж, нэмэгдүүлэх, уг салбарын хариуцлагын тогтолцоог иргэдийн оролцоотойгоор сайжруулах зорилгоор 2010 онд байгуулагдсан, иргэний нийгмийн 37 байгууллага, орон нутагт 11 салбартай үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага юм.

Бид 2016, 2020 оны сонгуулийн өмнө улс төрийн намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгах саналаа гишүүн байгууллага, салбар зөвлөлүүдээр хэлэлцүүлэн хүргүүлж байсан. Бидний санал парламентад суудалтай намуудын мөрийн хөтөлбөр, улмаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөнд тусаж, хэрэгжин зохих үр нөлөөтэй байгаад бид урамшин ээлжит саналыг дараах 5 чиглэлээр боловсруулан хүргүүлж байна:

1. Тэгш хамран сургах чанартай боловсрол
2. Боловсролын санхүүжилт
3. Боловсрол салбарын жендерийн хариу үйлдэл үзүүлэх байдал
4. Боловсролын салбар дах хүүхэд хамгаалал
5. Боловсролын салбарын засаглал, нийгмийн эгэх хариуцлага

Бид 2020 оноос хойш боловсролын тулгамдсан асуудлуудаар өөрсдийн болон бусад байгууллагуудын хийсэн судалгаа, гишүүн байгууллагууд, салбар зөвлөлүүдийн хийж гүйцэтгэсэн мониторинг, бодлогын хэрэгжилтийн судалгаа, иргэдийн цуглуулсан тоон болон чанарын мэдээлэлд хийсэн дүн шинжилгээнд суурилан саналаа боловсрууллаа.¹

Дэлхий даяар Ковид-19 цар тахлаас үүдэлтэй сурлагын хоцрогдлыг арилгах, 2030 он хүртэл Тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилгын хэрэгжилтийг хурдасгах зорилгоор Боловсролыг хувирган өөрчлөх санаачилга хэрэгжиж, Монгол улс боловсролын оролцогч талуудын хэлэлцэн тогтсон чиглэлүүдээр олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө үүрэг амлалт авсан.

“PISA – 2022” Сурлагын амжилтын олон улсын үнэлгээнд Монгол улс анх удаа хамрагдаж, суралцагчид математик, унших чадвар, байгалийн ухаан гэсэн үндсэн гурван агуулгын хүрээнд үнэлүүлжээ. Математикийн хичээлийн тухайд манай улс үнэлгээнд хамрагдсан нийт улсын дунджаас 2.3 жил, Азийн дунджаас 1.2 жилээр хоцорч байна. Математикийн сорилуудад хамрагдсан Монгол сурагчид тулгарсан асуудлыг шийдвэрлэхэд математикийн мэдлэгээ хэрэглэх, учир шалтгааныг илрүүлэх чадвараар сул үнэлэгджээ. Унших чадварын тухайд 81 орноос 65 дугаарт эрэмбэлэгдэж, уншиж

¹ www.all4education.mn болон www.uib.mn сайтуудаас дэлгэрэнгүйг харна уу.

ойлгох, өөрийгөө илэрхийлэх, эргэцүүлж бичих, дүгнэлт хийх ур чадвар тааруу гэж дүгнэгдсэн нь олон улсын дунджаас 5 орчим жил, Азийн дундаж хүүхдүүдээс 2.5 жилээр хоцорч байна. Байгалийн ухааны үнэлгээгээр манай сурагчдыг байгаль, технологийн аливаа үзэгдлийг тайлбарлах, асуудлуудыг шийдэхэд шинжлэх ухаанч эрэл хайгуул хийх, өгөгдөл мэдээллийг тайлбарлах ур чадвар сул гэж дүгнэсэн байна. Монгол сурагчид олон улсын дунджаас 3 орчим жилээр, Азийн хүүхдүүдээс 1.8 жилээр хоцорчээ.

Дараагийн 4 жил нь шинээр батлагдсан Боловсролын багц хуулийг хэрэгжүүлэх, сургуулийн өмнөх ба ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэх хариуцлагын жил байх болно. Мөн боловсрол сургалтын чанарыг² сайжруулах бодлогын шийдлүүдийг шаардсан жилүүд байх болно гэж Иргэний нийгмийн байгууллагууд харж байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

² Боловсролын чанар бол олон талт ойлголт бөгөөд зөвхөн сурагчдын тестийн дүнгээр явцууруулан харахгүй байх шаардлагатай. Боловсролд шаардлагатай нөөц, сайтар бэлтгэгдсэн багш нар, ач холбогдолтой агуулга зэрэг орц, эрүүл хоол хүнс, хүчирхийлэл дарамтгүй сургалтын орчин, багш сурагчийн эрх тэгш, таатай харилцаа, эцэг эхийн дэмжлэг зэрэг үйл явц болон хувь хүний сургалтын үр дүн (унших чадвар болон математикийн суурь чадварын түвшин гэх мэт), нийгмийн үр дүн (урт наслалт, ажил хөдөлмөр эрхлэлт, иргэний идэвхтэй оролцоо, гэмт хэргийн бууралт гэх мэт) зэргийг агуулж байдаг.

НИЙГМИЙН ЭВ ЭЕИЙГ БЭХЖҮҮЛЖ, АМАР АМГАЛАН, АРДЧИЛСАН, ТЭГШ ХАМРУУЛСАН, ИННОВАЦЛАГ, ЭГАЛИТАР НИЙГМИЙГ БАЙГУУЛАХЫН ТӨЛӨӨ

Нийгэм-эдийн засаг, улс төрийн нөхцөл байдал

Эрх мэдэл, баялаг, нөөц цөөн хэдэн хүний гарт төвлөрсөн, төрийн эрх мэдэлтнүүдийн дунд авлига, хулгай газар авсан, ядуурал 30 хувиас буудаггүй, өргөн хэрэглээний эд зүйлсийн үнэ улам өндөрсөж, өрийн дарамт, хүнсний аюулгүй байдал, цахилгаан эрчим хүчний доголдол, түлш шатахууны хомсдол нүүрлэсэн, ажилгүйдэл, ялангуяа хөдөлмөрийн насны залуу эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт тасралгүй буурч байгаа, байгаль экологийн тэнцвэр алдагдсан, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг ослын тоо нэмэгдэж, тэгш бус байдлыг улам гааруулсан цаг үед энэ сонгууль явагдах гэж байна. Тухайлан нийслэл хотын хувьд засаглалын хямралтай, агаарын бохирдол, замын түгжрэл, боловсролын хүртээмж, төлөвлөлтийн хуудуу, нийтийн тээврийн үйлчилгээ зэрэг хуримтлагдсан шийдвэрлэхэд ярвигтай асуудлууд хүлээж байна.

Иргэд бид шударга ёс тогтсон, эдийн засгийн өсөлт хүн бүрд наалдсан, эрхээ эдэлж, боловсрол, эрүүл мэнд зэрэг төрийн голлох үйлчилгээг үнэ төлбөргүй, чанартай хүртсэн, хүний амьдралын чанарт нөлөөлөх дэд бүтцүүд байгуулагдсан эрх тэгш, амар амгалан нийгэм, хөгжлийг хүсэж байгаа билээ.

Монгол улсын сүүлийн 30 жил баримталсан неолиберал эдийн засаг-улс төрийн замнал, бүхнийг зах зээлийн зарчмаар шийдэх гэсэн оролдлого амжилтгүй болж, бидний хүлээсэн хөгжил дэвшлийг авчирсангүй гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй байна.

Нийтийн бодлогын орон зайг ашиг хөөсөн хувийн хэвшлийнхэн эзэлж, хүний эрхээс өөрсдийн олох ашгаа дээгүүр тавьснаар нийгэмд тэгш бус байдал улам гүнзгийрч, хүн амын тодорхой хэсэг ядууралд сэхэх аргагүй живлээ. Хүний сайн сайхан байдал, эрх, эрх чөлөөг компани аж ахуйн нэгжийн олох ашгаас дээгүүр тавьсан шинэ бодит ертөнцийг бүтээх тогтолцооны өөрчлөлт бидэнд хэрэгтэй байна. Хөгжлийн үйл явцад оролцох иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын эрх, орон зайг олгохоос энэ өөрчлөлт эхэлнэ. Монгол хүний мөн чанар, цөөн хүн амтай, жижиг гүрний ашиг сонирхол, эдийн засаг нийгмийн онцлогт нийцсэн, нинж уужуу сэтгэл, хэтийн зорилготой, ухаант Монгол хүмүүнийг сурган төлөвшүүлэх боловсролыг хөгжүүлснээр хөгжил дэвшил ирнэ гэдэгт бид баттай итгэж байна.

ЯАГААД БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ МӨРИЙН ХӨТӨЛБӨРТ ТУСАХ ЁСТОЙ ВЭ?

Монгол улсын хувьд эн тэргүүнд шийдэх ёстой 3 үндсэн асуудал байна: **Ажилгүйдэл, Ядуурал ба Нийгмийн тэгш бус байдал.**

1. Монгол Улсын ядуурлын түвшин 1998 оноос хойш хурдацтай буурч өнөөгийн түвшинд хүрсэн хэдий ч сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд дорвитой өөрчлөлт гараагүй байна.
2. Ажилгүйдлийн түвшин 2022 онд 6.7 хувьд хүрч буурсан ч бусад орнуудтай харьцуулахад өндөр байгаа юм.
3. Сүүлийн жилүүдэд манай улсын эдийн засгийн өсөлтөд ахиц дэвшил гарч нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2010 оноос 1.6 дахин нэмэгдсэн сайн үзүүлэлтэй байгаа ч хүн амын амьжиргаа болон орлогын тэгш бус байдал аймаг, бүсийн түвшинд буурахгүй байна. Манай улсад хүний хөгжлийн тэгш бус байдал бага ч гэсэн буурсан боловч хангалттай хэмжээнд буурахгүй байгааг илтгэж байна.

Энэ зангилаа 3 асуудлыг шийдвэрлэхэд голлох нөлөөтэй салбарыг **БОЛОВСРОЛ** гэж судлаачид үзэж байна.

НОТОЛГООГ харуулбал:

1. “Ядуурлын дүр төрх” судалгаа (ҮСХ, 2020)

Монгол Улс боловсролд хамрагдах түвшний үзүүлэлтээр, ялангуяа залуучуудын хувьд, бүс нутагтаа тэргүүлж байгаа боловч ядуу ба ядуу бус хүн ам боловсролын түвшнээрээ илт ялгаатай байна. Ядуу давхаргын хүмүүсийн ихэнх нь дунд буюу ахлах ангийн боловсролоос цааш суралцаагүй, тэдний арвын нэг нь л дээд боловсролтой байх агаад харин хамгийн өндөр амьжиргааны түвшинтэй 20 хувийн тэн хагас нь дээд боловсролтой байна.

Монгол Улсын нийт хүн амын гуравны нэг нь хүүхдүүд бөгөөд ойрын жилүүдэд хүн ам зүйн дивидендийг угтана. Залуучууд олноороо ажиллах хүчинд нэгдэх тул үлэмж хөрөнгө оруулалтаар хөдөлдөг уул уурхайн салбар төдийгүй олон бүтээлч салбаруудад ажлын байр олноор бий болгох шаардлагатай. Түүнчлэн хүүхэд, залуучуудын хөгжилд хөрөнгө оруулж, ур чадварыг нь сайжруулах, ажиллах хүчинд эмэгтэйчүүдийн хувьд оролцох шударга, эрх тэгш нөхцөлийг дэмжих нь шийдвэрлэх ач холбогдолтой байх болно.

2. Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагддаг өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, (Др. Проф. Д.Больтогтох нар, ННФ, 2024)

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагддаг өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтэд боловсрол, нас, статус буюу өрхийн гишүүний үүрэг болон дүүрэг, хороонд ажил хайгчаар бүртгүүлсэн байдал зэрэг хүчин зүйл нөлөөлж байгаа нь ажиглагдлаа. Хан-Уул дүүрэгт амьдардаг, 45-55 насны, дипломын боловсролтой, өрхийн тэргүүний одоо ажил эрхлэх магадлал хамгийн өндөр буюу 0.69, Сонгинохайрхан дүүрэгт амьдардаг, 25-34 насны, мэргэжлийн боловсролгүй, ач, зээгийн хувьд одоо ажил эрхлэх магадлал хамгийн бага буюу 0.14 байна.

Боловсролын хувьд, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагддаг нийт өрхийн тэргүүний 1.8 хувь нь дээд, 66.1 хувь бүрэн дунд боловсролтой өрхийн тэргүүн зонхилж байна.

Боловсролтой байдал нь ажил эрхлэлтэд эерэг нөлөө үзүүлж байгаа тул хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхийн тул өрхийн гишүүний боловсролд анхаарах нь зайлшгүй юм.

15-24 насны залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрүүдийг эрчимжүүлэх нь чухал юм. Түүнчлэн, боловсролын байгууллагын зүгээс мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг дунд сургуулийн сургалтын хөтөлбөрт оруулах, ажлын байртай танилцах аялал, төрөл бүрийн мэргэжлийн залуучуудтай уулзалт, өдөрлөг зохиох гэх мэт өнөөгийн залуучуудын хэрэгцээ, сонирхолд нийцсэн үйл ажиллагаануудыг зохион байгуулахаас гадна ажил олгогчдын зүгээс залуучуудыг сонсох, урам зоригийг нь хугалахгүй байх, дагалдуулан зааж сургах зэргээр ажлын байран дээр зөвлөн туслах нь тэдний тогтвортой хөдөлмөр эрхлэлтэд чухал түлхэц болох талтай.

3. Боловсрол ба хөдөлмөр эрхлэлт судалгаа, (ҮСХ, 2020)

Манай улс хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхийн тулд боловсролын салбарыг дэмжих, хүмүүсээ сургах тал дээр онцгой анхаарах нь зүйтэй байна. Боловсрол нэмэгдэх хэрээр хүүхдээ илүү боловсролтой болгох хандлага харагдаж байна. Боловсрол нь хөдөлмөр эрхлэлтэд чухал нөлөөтэй нь гэдэг нь нотлогдож байна. Тухайлбал:

- Сургуульд сурсан жил нэг жилээр нэмэгдэхэд хөдөлмөр эрхлэх магадлал нь 6.5 хувиар нэмэгдэж байна.
- Эцэг, эхийн боловсролын түвшин нь хүүхдийн боловсролын түвшинтэй хүчтэй хамааралтай байна.
- Боловсролгүй эхийн хүүхдийг боловсролтой эхийн хүүхэдтэй харьцуулахад 2.3 жилээр бага жилээр сургуульд суралцаж байна.
- Боловсролгүй эцгийн хүүхдийг боловсролтой эцгийн хүүхэдтэй харьцуулахад 1.3 жилээр бага жилээр сургуульд суралцаж байна.
- Дээд боловсролтой эхийн хүүхдийг дээд боловсролгүй эхийн хүүхэдтэй харьцуулахад 1.1 жилээр илүү жилээр сургуульд суралцдаг байна.

Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд иргэдэд ямар нэг мэргэжил эзэмшүүлэх үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэх нь үр дүнтэй байна. Мэргэжилтэй хүнийг мэргэжилгүй хүнтэй харьцуулахад хөдөлмөр эрхлэх магадлал нь 21.5 хувиар илүү байна. Халамжийг зорилтот бүлэгт нь өгч, ажлын байрыг нэмэгдүүлэх, мэргэжил олгох сургалтыг идэвхжүүлэх шаардлагатай байна.

4. “Цалин болон халамжийн бодлого иргэдийн ажил эрхлэлтэд үзүүлж буй нөлөө” судалгаа (“Санхүүгийн хүртээмж хөгжил санаачилга” ТББ, ННФ, 2023)

Монгол Улсад 2005-2014 оны хооронд төрөлтийн хэмжээ 1.8 дахин өссөнөөс шалтгаалан ирэх жилүүдэд хөдөлмөрийн насны хүн ам нэмэгдэх төлөвтэй байна. Ажиллах хүчний оролцооны түвшин буурах хандлагатай бөгөөд үүнд эмэгтэйчүүдийн болон залуучуудын оролцооны түвшний бууралт голчлон нөлөөлж байна.

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд дараах асуудлууд тулгарч байна. Үүнд: (1) ажиллах хүчний оролцооны түвшин буурч байна, (2) ажилгүйдлийн түвшин бусад

орнуудаас өндөр, (3) эрэлт, нийлүүлэлтийн нийцгүй байдал, (4) хөдөлмөрийн бүтээмж багатай салбарт ажиллах хүчний ихэнх хэсэг ажиллаж байна, (5) нийгмийн халамжийг хавтгайруулан олгосноос зорилтот бүлэгт хүрч чадахгүй байна. Эдгээр асуудлуудыг шийдвэрлэхэд:

1. Ирээдүйн ажиллах хүчний ур чадвар, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор боловсролын чанарыг сайжруулж, мөн нийлүүлэлт илүүдэлтэй байгаа ажил мэргэжлээс хомсдолтой талд ажиллагчдыг татах зорилгоор мэргэжлийг сурталчлах, мэргэжил сонголтыг төрөлжүүлэх, хомсдолтой талд ажиллах мэргэжилтнүүдийг дэмжих бодлого, зохицуулалт хэрэгжүүлэх. Тухайлбал:

- Багш мэргэжлийн хүний нөөцийг нэмэгдүүлэх, тэдний хөдөлмөрийн үнэлэмжийг сайжруулах, урт хугацаанд бодлогоор дэмжин, ажиллах нөхцөлд анхаарах;
- Байгалийн шинжлэх ухааны сургалтын хөтөлбөрийг дахин боловсруулах;
- Ирээдүйд ажиллах хүч улам хомсдох ажил мэргэжлийг тодорхойлж, тэдгээрийг нийтэд таниулан сурталчлах;
- Хүн амын хэтийн төлөвт тохируулж, дэд бүтэц, хүний нөөцийг бэлдэх (сургууль, цэцэрлэг, хичээлийн тоног төхөөрөмж, багш, сурган хүмүүжүүлэгч зэрэг).
- Их, дээд сургууль болон МСҮТ мөн сургалтын төрөл бүрийн байгууллагуудын мэргэжлийн хөтөлбөрийг ирээдүйн ажлын байрны эрэлтэд нийцүүлэн шинэчлэх, зөвлөгөө, чиглэл өгөх арга хэмжээг хэрэгжүүлэх;

Боловсролын чанарыг сайжруулах нь хөдөлмөрийн нийцгүй байдлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд нөлөөлнө.

5. “Орлого, хэрэглээний тэгш бус байдал” (ҮСХ, 2020 он)

Нийгмийн тэгш бус байдлыг бууруулах суурь болсон боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг санхүүжүүлэх бодлогод нэн тэргүүнд анхаарах шаардлагатай байна. Манай улсад 2012 оноос хойш өнөөг хүртэл тэгш бус байдлаар засварласан боловсролын индексийн үзүүлэлт тогтмол нэг түвшинд байна. Харин боловсролын индексийн алдагдсан боломж улсын дунджаар бага хувьтай байгаа нь хэвээр хадгалагдсаар байна. Энэ нь боловсрол эзэмших залуучуудад хүйс, оршин суугаа газар, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаатай байдал, хүн амын амьжиргааны түвшнээс шалтгаалан боловсролын чанар, хүртээмж ялгаатай байсаар байгааг харуулж байна.

Жосеф Стиглицийн “Тэгш бус байдлын хор уршиг” сэдэвт судалгаанд “эдийн засгийн тэгш бус байдал нь улс төрийн тэгш бус байдлын үндсэн суурь болдог. Өндөр орлоготой бүлэг нь улс төрийн илүү эрх эдэлсэн нийгэмд тэдэнд ногдуулсан татвар хамгийн бага байна. Зах зээлийн эдийн засгийн энэ мэт тааламжтай бус үр дүнг залруулах нэг гол арга зам нь татвараар дамжуулан хэрэгжүүлэх төсвийн дахин хуваарилалтын бодлого юм” гэжээ.

Төсвийн бодлогын хамгийн чухал хэсэг нь татварын тогтолцоог илүү шударга болгох явдал юм. Энэ нь татварын өсөн нэмэгдэх тариф буюу орлого ихтэй хэсэг нь нийгмийн өмнө илүү өндөр хариуцлага хүлээх тогтолцоо юм. Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг олборлож буй компаниудад илүү татвар ногдуулах нь энэ зарчмын бас нэг хэсэг юм.

6. Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагддаг өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа (Др. Проф. Д.Больтогтох нар, ННФ, 2024)

Нийгмийн халамжийн тогтолцоо нь зорилтот өрхийн орлогын баталгааг нэмэгдүүлснээр ядуурлын тэгш бус байдлыг бууруулах, эрүүл мэнд, боловсролын орчин, үр дүнг сайжруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, цаашлаад хүний хөгжил, бүтээмжийг дээшлүүлж, улс орны эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чухал үүрэгтэй. Гэтэл манай оронд зорилтот бүлгийн амьжиргаанд чиглэсэн халамжийн үйлчилгээ, түүнд ногдох санхүүжилт хязгаарлагдмал байна. 2017-2021 оны нийгмийн халамжийн үзүүлэлтүүдээс харвал энэ төрлийн халамжийн үйлчилгээ хүртэгчийн тоо 314,931-ээс 167,280 болж, улмаар санхүүжилт нь буурчээ.

Ядуурлын түвшин нь 27.8 хувьтай байгаа хөгжиж буй манай орны хувьд, нэн тэргүүнд ядуурлын түвшнээс доогуур амьдарч буй иргэдийнхээ амьжиргааг дээшлүүлэхэд халамжийн бодлогыг чиглүүлэхийн оронд гол санхүүжилтээ зорилтот хүн амын 91 хувь нь хүртдэг хүүхдийн мөнгөн тэтгэмжид зарцуулахын зэрэгцээ нийгмийн халамжийн тусламж, дэмжлэг зайлшгүй шаардлагатай өрхүүдэд болзол тавьж, тэдэнд зориулсан санхүүжилтээ бууруулж байна.

2023 оны 3 дугаар сарын нийгмийн халамжийн сангийн зарцуулалтын тайланг харвал, нийт зарцуулалтын 69 хувийг хүүхдийн мөнгөн тэтгэмж эзэлж байна.

7. Амьжиргааны түвшин доогуур өрхийн суралцагчийг сурах бололцоогоор хангах талаарх бодлого, түүний хэрэгжилт, Судлаач Ч.Бат-Уянга, “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, 2021 он

Боловсрол нь чадавхын эрх болохын хувьд нийгэм, эдийн засгийн хувьд хязгаарлагдмал хүүхдүүд, томчуудад ядуурлаас өөрсдийгөө гаргах, нийгмийн амьдралд бүрэн төгс оролцох арга замаа олох үндсэн хэрэгсэл нь болдог. Иймээс Тогтвортой хөгжлийн зорилгод ч хүн бүр амьдралынхаа туршид суралцаж хувь хүний болон мэргэжлийн хувьд хөгжих боломжоор хангагдах ёстой хэмээн тусгайлан заасан нь бий. Хэдий тийм ч хүүхдүүд нийгэм-эдийн засгийн хувьд анхнаасаа тэгш бус, аливаа ялгаатай нөхцөл (гарал угсаа, нийгмийн давхарга, ядуурал, хөгжлийн бэрхшээл, хүйс, жендер гэх мэт) нь тэднийг боловсрол эзэмшихэд саад учруулсаар байна. Гэтэл бага наснаасаа боломжоор хязгаарлагдана гэдэг нь насанд хүрсэн хойноо чанартай боловсролд хамрагдах боломжоос хоцрох, эсвэл сургуулиа бүрэн дүүргэж чадахгүй байдалд хүрэх; үндсэн чадвар, чадамж хангалтгүй, эсвэл нийгэмд нэр хүндтэй, цалин сайтай ажил хөдөлмөр эрхлэхэд нь шаардлага хангахгүй мэдлэг боловсрол эзэмших магадлалтай гэсэн үг юм. Иймээс ялгаатай байдал нь үе дамжсан сул талыг бий болгохоос гадна хувь хүн болоод улс үндэстний хувьд нийгэм, эдийн засгийн үр шимийг хүртэхэд саад тотгор учруулдаг.

“Амьжиргааны түвшнээс доогуур өрхийн суралцагч” хэмээн зөвхөн орлогын ядуурлаар тодорхойлох нь тухайн бүлэгт чиглэсэн суралцагчид тусгайлсан бодлого хэрэгжүүлэхэд дөхөм хэдий ч хэрэгжүүлж буй бодлого нь зөвхөн сурах бичиг, дүрэмт хувцас, хичээлийн хэрэгсэл зэрэг материаллаг орчныг хэсэгчлэн хангахад чиглэж буй сул тал ажиглагдлаа. Иймд олон улсын ойлголт болох “нийгэм-эдийн засгийн статус доогуур” гэх агуулга руу бодлогыг чиглүүлж нийгэм-эдийн засгийн бүхий л чиглэлээр цогц дэмжлэг үзүүлэн сурах нөхцөл, бололцоог хангах шаардлагатай.

8. PISA 2022 Сурлагын амжилтын олон улсын үнэлгээний тайлан (Монгол улс. БШУЯ, ЭЗХХАБ. 2023 он)

Нийгэм-эдийн засгийн статус доогуур өрхийн хүүхдүүдийн математикийн үнэлгээ нийгэм-эдийн засгийн статус дээгүүр хүүхдүүдийнхээс 94 оноогоор доогуур гарсан нь ЭЗХХАБ-ын дундажтай (93 оноо) ойролцоо байна. Үнэлүүлсэн 3 хичээлээр хот хөдөөгийн суралцагчдын дунд гарсан ялгаа нь (сумын хүүхдүүдийн 2 жилийн хоцрогдол) мөн л нийгэм-эдийн засгийн статусын нөлөөтэй гэсэн дүн гарчээ.

Улс орнууд PISA үнэлгээгээр илрүүлсэн үр дүнг боловсролын тогтолцоондоо өөрчлөлт хийх боломж хэмээн үзэж ул суурьтай, нарийн шинжилгээ, дүгнэлт хийж өөрчлөлтийг эхлүүлдэг байна. “Нийгмийн халамжийн тухай хууль”-ийн тавдугаар зүйлд заасан нийгмийн халамжийн үйл ажиллагааны төрөлд нийгмийн халамжийн тэтгэвэр, нийгмийн халамжийн тэтгэмж, нийгмийн халамжийн үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээ зэрэг багтдаг. Эдгээрээс Нийгмийн хөгжлийн үйлчилгээ нь ядуурлын эсрэг чиглэсэн гол арга хэмжээ юм. Уг арга хэмжээгээр нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэнд боловсрол, эрүүл мэнд, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлдэг. Үүнд Боловсролыг дэмжих үйлчилгээний хүрээнд өрхийн гишүүн-иргэний хүүхэд сургуулийн өмнөх боловсролын болон ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа бол хичээлийн хэрэгсэл, сурах бичиг, дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлтөд хамруулахаар заасан нь туйлын хангалтгүй байна.

Халамжийн бодлогын үндсэн зорилго болох “Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах”-д төвлөрсөн “Нийгмийн хөгжлийн үйлчилгээнд” багтах боловсролыг дэмжих үйлчилгээнд нийгмийн халамжийн дэмжлэг, тусламж зайлшгүй шаардлагатай өрхийн хүүхдүүдийг хамруулж, сурлагын амжилтад үзүүлэх нөлөөг багасгахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх санхүүжүүлэх шаардлагатай байна.

НЭГ. ТЭГШ ХАМРАН СУРАХ, АМЬДРАХ, ХӨГЖИХ СОЁЛЫГ БИЙ БОЛГОЖ, ХАМТААРАА САЙХАН АМЬДРАХ НИЙГМИЙН ТӨЛӨӨ

Хүүхдийн эрхийн тухай конвенц, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгууд, "Алсын хараа 2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд ТЭГШ ХАМАРСАН НИЙГЭМД ХҮҮХЭД БҮРИЙН СУРЧ БОЛОВСРОХ ЭРХИЙГ ЭДЛҮҮЛЭХИЙН ТУЛД

- Тэгш хамрагдалт нь бүхий л суралцагчдын суралцахуйг сайжруулдаг тул боловсролд тэгш хамран сургах үйл явцыг сайтар төлөвлөж хэрэгжүүлж чадвал хүүхэд, өсвөр үеийнхний сурлагын амжилт, нийгэм-сэтгэл зүйн хөгжил, өөрийгөө хүндлэх, үе тэнгийнхнээ хүлцэх, хүлээн зөвшөөрөхөд ахиц дэвшил авчирдаг.
- Тэгш хамруулах боловсролыг хэрэгжүүлэх явцад үүнийг зөвхөн нийгмийн маргинал бүлгийн эрх ашигт төвлөрсөн зарчим мэтээр хязгаарлагдмал утгаар ойлгох, хэрэглэх явдал түгээмэл байгааг халж, боловсролд тэгш хамран сургах нь боловсролоор дамжуулан нийгэм дэх хэвшмэл үзэл ойлголт, ялгаварлан гадуурхалттай тэмцэх, хүний нийгмийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, хүлцэн тэвчил, харилцан ойлголцол, нийгмийн шударга ёс ноёлсон нийгэмд хүрэх арга зам гэж үздэг болсон.
- Боловсролд тэгш хамруулан сургах нь нэг талаас хүн бүрийн ялгаатай хэрэгцээнд нийцэхүйц, нөгөө талаас, тухайн хүүхдийн суралцах, хөгжих, оролцоонд тулгарч буй аливаа саад тотгорыг арилгахад чиглэсэн бодлого, зохицуулалт, хөрөнгө нөөц хуваарилалт хийх үйл явц, түүний үр дүн гэж нийтээр ойлгож хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- Холбогдох бүх яам, албан тушаалтан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага, төрийн бус байгууллагын хоорондын хамтын ажиллагааг зохицуулж чадвал боловсролд тэгш хамруулах тогтолцоог бий болгож чадна.

Үндэсний хэмжээнд зайлшгүй авах арга хэмжээнүүдийн санал:

1. Хүн болгон өөрийн гэсэн онцлог шинж чанар, сонирхол болон харилцах, сурах, хөдөлмөрлөх ялгаатай хэрэгцээтэй учраас тухайн хүний амин чанар (identity), амьдралын нөхцөл байдал, чадвараас үл шалтгаалан чанартай суралцах эрхтэйг хүлээн зөвшөөрч, боловсролын салбарт тэгш хамран сургах тогтолцооны шинэчлэл өөрчлөлтийг үргэлжлүүлэх
2. Энэ үйл явцын хүрээнд зөвхөн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх биш, хүүхэд бүр суралцах, хөгжих үйл явцад жигд оролцох, үр дүнтэй суралцах эрх тэгш байдлыг хангах, хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний хүрээг өргөтгөх, хэрэгжүүлэх

арга замыг сайжруулах, сургалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх, багшлахуй-суралцахуйг хүртээмжтэй болгоход хөрөнгө оруулах ажлуудыг нэн даруй хийх

3. Тэгш хамруулах хандлага-аргазүйг "мэргэжилтний" хийх ажил гэж харахгүй байх, суралцахуйн түгээмэл загвар нь багш бэлтгэх болон мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийн цөм хэсэг байх, бүх суралцагчийг боловсролд тэгш хамран сургахтай холбоотой сургалтын арга зүй, ангийн зохион байгуулалтаас эхлээд хөтөлбөрт тохируулга хийх, дэмжлэгийн багаар ажиллах, сурлагын амжилтын үнэлэх аргууд хүртэлх олон тооны ур чадваруудад багшийг сургах ёстой. Багш нар сурагчдын хэрэгцээг мэдэх, тохирох дэмжлэг, тохируулгат арга хэмжээг хэрэгжүүлэхэд багш бэлтгэх/мэргэжил дээшлүүлэх сургалтыг чиглүүлэх, дэмжлэг үзүүлэх
4. Нийгэм, эдийн засаг, нөхцөл байдлын олон талт, зарим үед давхацсан хүчин зүйлүүдийг судалж тогтоон, ангийн, нэг бүлгийн хэмжээнд, заримдаа хувь хүүхдэд чиглэсэн дэмжлэгийн арга хэмжээнүүдийг бодлого, төсвийн хувьд улам төгөлдөржүүлэх
5. Тусгаарлан сургах тогтолцоо болох тусгай сургуулиуд нь бодлогын анхаарал, төсвийн дийлэнх хэсгийг тэгш хамруулах тогтолцооноос татан авч байгааг анхаарч, ердийн сургуульд тэгш хамруулахад чиглэсэн бодлогын шилжилтийг нэн даруй хийх
6. Боловсролд тэгш хамран сургах нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хамаатай гэж харах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тэгш хамран сургахад зөвхөн налуу зам, лифт зэрэг материаллаг орчныг бүрдүүлэх хэрэгтэй гэж явцуу ойлгож, боловсролоос гадуурхагдах, орхигдох эрсдэлтэй бусад бүлгийн хүүхдүүдийг орхигдуулахаас зайлсхийж, нийгмийн ялгаатай бүлгүүдийг эрх тэгш хамруулахад тусгайлсан бодлогын арга хэмжээ, төсөв шаардагдана гэдгийг хүлээн зөвшөөрөх
7. Өнөөдөр бий болсон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг болон бусад ялгаатай бүлгийн хүүхдүүдийг ердийн сургуульд тэгш хамран амжилттай сургах дэмжлэгийн тогтолцоог бүрэн болгож, дээд болон мэргэжлийн боловсрол, сургалтын түвшинд тэгш хамруулан сургах нөхцөлийг бүрдүүлэхэд онцгой анхаарах, дэмжих үйлчилгээний бүрдлүүдийг боловсрол сургалтын байгууллагатай холбох
8. Бага насны хөгжил, оролцооны хувьд хөгжлийн хоцрогдол, хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэг, сургалтын эрэлт хэрэгцээг тогтоох үнэлгээ, дэмжлэг, эрт оролцооны хөтөлбөрийг салбар дундын байдлаар (нийгмийн эрүүл мэнд, гэр бүл, нийгмийн халамж, хоол тэжээл, хүүхдийн эрх, хамгаалал) зохион байгуулж хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Бага насны хүүхдийн халамж, үйлчилгээ нь хөгжлийн бэрхшээлтэй болон нийгэм-эдийн засгийн статус доогуур өрхийн хүүхдүүдэд үнэлж баршгүй ач холбогдолтой бөгөөд боловсролоос үр шим хүртэх чадавхыг бэхжүүлэх, тэдний сургуульд элсэн сурах, тасралтгүй үргэлжлүүлэн сурахад тустай.
9. Боловсролын Ерөнхий болон бусад хуулиар хүлээсэн чиг үүргээ биелүүлэхийн тулд бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулахдаа ашиглах нарийвчилсан мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй болон бусад ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн хамрагдалт, анги дэвшилт, төгсөлт, сурлагын чанарын болон зарцуулсан төсвийн тоо мэдээллийг ялгаж гаргах, БУМИС-ийн мэдээллийг нь судлаач, ИНБ-уудад ашиглах боломжтой болгох,
10. Багш бэлтгэж байгаа их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт ялгаатай хэрэгцээтэй сурагчдын эрх, үл ялгаварлан гадуурхах, эрх тэгш байдлын талаарх мэдлэг ойлголт, ялгаатай бүлгийн саад тотгорыг олж мэдэх, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн сургалт, хичээлээ төлөвлөх, зохион байгуулах арга зүйг тусгаж өөрчлөх

11. Монгол орны нөхцөлд гэр хороолол ихтэй, сургуулийн барилгууд олон давхар, шат босго ихтэй, нийтийн тээвэр хүртээмжгүй, зам талбай ихэнхдээ хүртээмжгүй байгааг эн тэргүүнд шийдвэрлэх
12. УИХ-ын гишүүд, Засгийн газрын гишүүд, боловсролын бодлого боловсруулагчид, орон нутгийн хэрэгжүүлэгчид боловсролд гарч байгаа парадигмын өөрчлөлтийг мэдэхгүй, "тусгай институц"-д хөрөнгө оруулах, тусгай сургууль, цэцэрлэг нэмж барихаар боловсролын хомсхон нөөцийг татах зэргээр Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа -2050"-ийн боловсролын зорилтыг тууштай хэрэгжүүлэхгүй эргэж буцаж, гуйвж дайвж байгааг таслан зогсоох
13. Монгол улсад үндэстний цөөнхийн хүүхдүүдэд эх хэлээрээ (казах, тува) суралцах нөхцөлийг бүрдүүлэх ажил эрчимжиж байгаа тул Монгол хэлний болон Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд заасан хос хэлний хөтөлбөр, хос хэлний сургалтын бодлого, хөтөлбөрийг боловсруулан батлах
14. Тодорхой хүүхдэд ядуурал, хөгжлийн бэрхшээл, жендер зэрэг шинж хослох, гурамслах нь тэдгээрийг сургуульд хамрагдах, цаашлаад чанартай боловсрол эзэмших боломжид сөргөөр нөлөөлж, тэдгээрийн эрсдэлт нөхцөлийг улам бүр доройтуулж байгааг бодлогын түвшинд харж шийдэх.
15. Боловсролын аливаа шатны төгсгөлд хийдэг үнэлгээнд ач холбогдол өгөхөөс татгалзаж, боловсрол эзэмших бүхий л явцад хийгддэг үнэлгээг илүүд үзэх нь боловсролд тэгш хамран сургах зорилгод үнэлгээг нийцүүлэх хүчин чармайлт болно. Боловсролын чанарыг сайжруулъя гэвэл үнэлгээг багш нар сурагчдын хэрэгцээг мэдэх, тохирох дэмжлэг, тохируулгат арга хэмжээг хэрэгжүүлэхэд анхаарах гэсэн өөр өнцгөөс хардаг болох
16. Малчин өрхийн 5 настай хүүхдэд сургуульд бэлтгэх хөтөлбөрийг хэрхэн оновчтой болгох, чанар хүртээмжийг сайжруулах бодлогын шийдлүүд хийх, дотуур байрны нөхцөлийг сайжруулах (халаалт дулаан, ус, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, цэвэр усны хангамжийг оруулаад) шаардлагатай тавилга хэрэгсэл, сургалтын материал, тоглоомоор хангах, хүрэлцэхүйц, хангалттай орон тоо батлах, шаардлагатай хувьсах зардал, төсвийг оновчтой хуваарилах, хүүхэд хамгааллын арга хэмжээг даруй авч хэрэгжүүлэх замаар дотуур байрны чанарыг сайжруулах, салбар дундын хамтын ажиллагааг дэмжих, сургуулийн зураглал хийх асуудалтай уялдаа холбоотой авч үзэх
17. Сургууль дээрх дээрэлхэлт, хүчирхийлэл нь зарим бүлгийн хүүхдийг үл хамрагдах, сургууль завсардах шалтгаан болдог. Нийгмийн хэм хэмжээ, стандартуудаас өөр гэж үзэгддэг бэлгийн, үндэстний болон шашны зэрэг цөөнхийн бүлгүүд, ядуу өрхийн хүүхдүүд, ялгаатай хэрэгцээтэй суралцагчид хүчирхийлэлд илүү ихээр өртдөг байна. Боловсролын орчин дах ялгаварлан гадуурхалт, үе тэнгийн дарамт, хүчирхийлэл улам нэмэгдэж байгааг хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр хийсэн судалгаануудын үр дүн нотолж байгаа тул боловсрол дах хүүхэд хамгаалалд салбар дундын зохицуулалт хийх
18. Сургуулийн бодлого, дүрэм журамд удирдах ажилтан, багш, ажилчдын хүлээх үүрэг хариуцлагад тэгш хамруулахад чиглүүлсэн өөрчлөлтүүдийг тусгах, ялангуяа сургуулиуд мэргэжлийн багш, зөвлөхтэй гэрээ байгуулан ажиллах, дохионы хэлээр харилцах багш, ажилтны чадамжийг бүрдүүлэх, ялгаатай бүлгийн, тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээ, онцлогт тохирох сургалтын хэрэглэгдэхүүн,

ном, сурах бичиг, тусгай тоног төхөөрөмжөөр хангах талаар аймаг, нийслэлийн боловсролын газрууд санаачилгатай, дорвитой ажиллах

19. Нийгмийн ялгаатай бүлгийн хүүхдүүдийг боловсролд тэгш хамран сургахын тулд нийгмийн хамгаалал, халамж, хүүхэд хамгаалал, эрүүл мэнд болон бусад салбарууд хамтран ажиллах эхлэл тавигдаж байгаа тул засаглалын бүтэц, санхүүжилтийн механизмыг хэлбэржүүлэн хэвшүүлэх
20. ЕБС, орон нутгийн түвшинд сургуулийн насны хүүхдүүд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй, бага орлоготой өрхийн хүүхэд зэрэг зорилтот бүлгийн хүүхдийн мэдээллийг цуглуулах, нэгтгэх, солилцох үйл явцыг сайжруулах шаардлагатай байна. Бүртгэлгүй, харьяалалгүй, түр оршин суугч өрхийн, нэн ялангуяа сургуулиас гадна байгаа сургуулийн насны хүүхдийн тоо, завсардсан шалтгааны талаарх мэдээлэл, бүртгэл сул байгаагийн улмаас сургуулийн гадна үлдэж байгааг хүлээн зөвшөөрч, тэдэнд боловсрол нөхөн олгох, бичиг үсэгт тайлах хүчин чармайлт тавих

ХОЁР. БОЛОВСРОЛЫН САНХҮҮЖИЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЖ, ЭРХ ТЭГШ, МЭДРЭМЖТЭЙ БОЛГОХЫН ТӨЛӨӨ

Хүн бүрийн сурч боловсрох эрхийг баталгаажуулах Тогтвортой хөгжлийн зорилгод хүрэхийн тулд санхүүжилт зөвхөн хамран сургалт руу хандаад зогсохгүй тэгш хамруулсан бөгөөд эрх тэгш байдлыг баталгаажуулахад чиглэгдэх хэрэгтэйг сануулж байна. Тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилгын эрх тэгш байдлыг санхүүжилттэй нь уясан “хүн амын эмзэг хэсэгт боловсролын нөөцийг дахин хуваарилах санхүүжилтийн механизм байгаа эсэх” гэсэн индикатор байдаг нь боловсрол дахь эрх тэгш байдлыг хангах буюу “хүүхэд бүрд амжилт гаргахад нь шаардлагатай байгаа нөөц, багш, үйл ажиллагаа, дэмжлэгийг үзүүлэх, санхүүжүүлэх” юм.

Боловсролын салбар улс орны хөгжлийн тэргүүлэх салбар гэдгийг санхүүжилтийн түвшинд баталгаажуулахыг иргэний нийгмийн байгууллагууд шаарддаг ба Ослогийн тунхаглал (2008)-аар анх дэвшүүлж Инчоны тунхаглал (2015)-аар баталгаажуулан зөвлөсөн санхүүжилтийн хэмжээ бол улсын төсвийн зардлын 15-20 %, эсвэл ДНБ-ний 4-6 %-ийг боловсролын салбарт зарцуулах зөвлөмж байдаг.

Сүүлийн 10 жилд Боловсролын төсвийн зарлагын улсын төсвийн нийт зарлагад эзлэх дундаж хувь 15.5%, ДНБ-д эзлэх дундаж хувь 4.7% байсан.

Монгол Улсад боловсрол олгох үйл ажиллагаа зардал ихээр шаарддагийг тооцож үзэн улсын төсвийн зарлагын 20%, ДНБ-ий 6%-д хүргэх шаардлагатайг судлаачид зөвлөдөг. Боловсролын салбарын тойм судалгаанд дараах гурван шалтгаанаар тайлбарласан байдаг. Үүнд:

- газар нутаг уудам бөгөөд хүн ам нь тархай суурьшдаг
- удаан үргэлжлэх өвлийн хүйтэн улирлаас хамааран дулаан, халаалтын зардал өндөр гардаг
- боловсролын салбар нь хөдөлмөр багтаамж болон орц ихтэй салбар учраас бусад салбартай харьцуулахад цалингийн зардал өндөр гардаг нь боловсролын үйлчилгээг хүргэх зардлыг ихээр нэмэгдүүлж байна.

Мөн малчдын хүүхдийг сургах дотуур байрны зардал, хувийн сургуулиудад өгөх төсвийн татаас зэргийг нэмбэл боловсролын зардал өндөр болно.

Боловсролын багц хуулиар боловсролын байгууллагын барилга байгууламж, түүний засвар үйлчилгээг нутгийн удирдлагын үүрэг, хариуцлага байхаар тогтоосон нь энэхүү санхүүжилтийн хэмжээ нь [орон нутгийн санхүүгийн нөөц дайчлах чадавх, боломжоос шалтгаалан] ихээхэн зөрүүтэй байдаг учраас сургалтын үйл ажиллагаа хэвийн явуулах нөхцөл алдагдаж, тэгш бус байдалд нөлөө үзүүлэх сөрөг үр дагавар харагдаж байна.

Үндэсний хэмжээнд зайлшгүй авах арга хэмжээнүүдийн санал:

1. Боловсролын салбарын санхүүжилтийг нэмэгдүүлэх, ялангуяа нэг суралцагчид ноогдох зардлыг эрчимтэй нэмэгдүүлэх
Олон улсын сурлагын амжилтын үнэлгээгээр (PISA) Монголын 15 настай хүүхдүүдийн сурч байгаа сургуулийн боловсрол сургалтын материал хэрэглэгдэхүүн, барилга байшингийн хүртээмж, чанар ЭЗХХАБ-ын ба Азийн улс орнуудын дундаж төдийгүй хөгжлийн адил түвшинтэй улсуудтай харьцуулахад нэлээд доогуур байна гэсэн дүн гарсан.
Мөн түүнчлэн энэ үнэлгээнд амжилттай гэж үнэлүүлдэг улс орнууд нэг суралцагчид 6-15 насанд нь өсөн нэмэгдэх дүнгээр дунджаар 91,132 ам.доллар зарж байхад Монгол улс 12,576 ам, доллар зарж байна.
2. Сургууль, цэцэрлэгийг санхүүжүүлж байгаа нэг суралцагчид ноогдох хувьсах зардлын хэмжээг жил бүр дорвитой нэмэгдүүлэн тогтоож байх
2022 оноос хувьсах зардлыг нэмсээр байгаа ч сургалтын үйл ажиллагааг хэвийн нөхцөлд явуулахад, тухайлбал сургуулийн үйл ажиллагааны урсгал зардал хүрэлцэхгүй хэвээр байна.
3. Ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн, хувьсах зардлын байршил, хэв шинж, хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүрийн тооцоолол, аргачлалыг тасралтгүй сайжруулах
Суралцагчийн онцлогоос хамааралтай хүчин зүйлсийг тооцсон итгэлцүүр: хамгийн чухал бөгөөд эрх тэгш байдалтай холбоотой зүйл бол суралцагчдын онцлог хэрэгцээтэй холбоотой нэмэлт итгэлцүүр байх шаардлагатай ба хүүхэд бүрийг амжилт гаргах боломжийг тэнцвэржүүлэхэд түлхэц болно.
Хөгжлийн бэрхшээл – одоогийн аргачлалд хөгжлийн бэрхшээлийг анхаарч үзэж байгаа хэдий ч тусгай сургуулийн суралцагчдад энэ боломж хүрч, ердийн сургуульд суралцаж байгаа хүүхдүүдэд хүртээмжтэй биш хэвээр байна.
Тухайн сурагчийн эх хэлээс хамаарсан итгэлцүүр – Зөвхөн Баян-Өлгий аймаг суралцаж байгаа казах хүүхдүүдээс гадна хэлний цөөнх тува хүүхэд, дохионы хэлээр суралцаж байгаа суралцагчийн хувьд сурах эрхээ эдлэхэд шаардагдах зардлуудыг гаргах санхүүжилт хэрэгтэй байна.
Тухайн орон нутгийн нийгэм эдийн засгийн статусыг тооцсон итгэлцүүр – тухайн сургууль оршин байгаа орон нутгийн ядуурлын түвшнийг харгалзаж тооцсон итгэлцүүрийг тооцох нь чухал болохыг Олон улсын сурлагын амжилтын үнэлгээний дүн харуулж байна.
4. Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлалын хэрэгжилтэд үнэлгээ, дүн шинжилгээ хийж сайжруулж байх, ИНБ-уудтай зөвлөлдөх, санал авах
5. Боловсролын салбар дах хүүхэд хамгаалал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, хөгжил, насан туршдаа суралцахуйн чиглэлээр салбар дундын санхүүжилтийг хэрхэн зохицуулах талаар бодлого удирдамж гарган хэрэгжүүлэх
6. Боловсролын бодлогоор олон улсын хөтөлбөрийн сургуулийг нэмэн байгуулж, төрийн өмчийн сургуулийг сургалтын хэл, хөтөлбөр, санхүүжилтийн ялгаатай 2 давхаргат болгон хувааж, төлбөртэй төрийн бус өмчийн сургуульд нэг хүүхдийн хувьсах

зардал, багшийн мэргэжил дээшлүүлэх зардал зэрэг санхүүжилтийг улсын төсвөөс олгож, хувийн цэцэрлэгийн хувьсах зардлыг 2 дахин нэмэгдүүлж хуваарилж байгаа зэрэг нь боловсрол дахь тэгш бус байдлыг улам гүнзгийрүүлэх үр дагавартай байгааг анхаарах.

7. Монгол улсын Үндсэн хуулийн 2-р зүйлийн 7-д төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно гэж заасан байдаг тул төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгт төрөөс тавих шаардлагаа нарийвчлах, төрөөс тавих хяналтаа боловсронгуй болгох, ОУ-ын хүний эрхийн гэрээгээр төрөөс хувийн сургуулийг санхүүжүүлэх үүрэггүй гэж заасан байдаг тул улсын төсвөөс дэмжлэг үзүүлэхээ зогсоох
8. Сургууль, багшийн гүйцэтгэлийн үнэлгээний аргачлалыг улам төгөлдөржүүлэх, боловсролын тэгш бус байдалд үзүүлэх нөлөөг багсгах арга хэмжээ авах
9. Боловсрол дахь дижиталчлалын давуу тал, сөрөг талыг урьдчилан харах, сургалтын чанар, тэгш байдал, үр ашгийн талаарх судалгаа нотолгоонд суурилсан шийдвэр гаргах, суралцагчийн хүний эрх, сайн сайхан байдал, аюулгүй байдал, мэдээллийн нууцыг хадгалах эрх зүйн зохицуулалт, бодлогоо боловсруулж батлах, урт хугацаанд гарах зардлын тооцоог хийж, туршиж байж нэвтрүүлэх
10. Боловсролын салбарт зориулж байгаа Хөгжлийн албан ёсны тусламжийн зарцуулалтыг Орон нутгийн боловсролын бүлгээр дамжуулан тайлагнадаг үр дүн, үр нөлөөг үнэлүүлдэг байх
11. Сургалтын тоног төхөөрөмж, үдийн цай, дотуур байрны хүүхдийн хоол, зөөлөн эдлэл, халаалт түлш зэрэг худалдан авалтын үйл явцыг тодорхой болгох, худалдан авалтын үе шатанд, ялангуяа хяналт тавихад эцэг эх, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл зэрэг нэмж оруулах
12. ИНБ-уудын хийсэн төсөв мөшгих, журам, аргачлалын хэрэгжилтийн үнэлгээг санхүүжүүлдэг байх
13. Боловсролын салбарын төсвийн төслийг УИХ-д өргөн барихын өмнө танилцуулж, ИНБ, ҮЭ-ээс санал авдаг, зөвлөлддөг байх
14. Боловсролын салбарын Аудитын тайлантай танилцах Үндэсний Аудитын Газар, яам, ИНБ-ууд хамтарсан уулзалт зөвлөгөөн хийх
15. Орон нутгийн түвшинд боловсролд зарцуулж байгаа төсвийн мэдээллийг үндэсний хэмжээнд цуглуулж дүн шинжилгээ хийх
16. Орон нутгийн түвшинд сургуулийн барилга байгууламж, түүний ашиглалт, урсгал засварын байдалд хөндлөнгийн үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлэх ажлыг ИНБ-уудаар гэрээлэн гүйцэтгүүлэх

ГУРАВ. БОЛОВСРОЛЫН ОРЧИН ДАХЬ ЖЕНДЕРИЙН МЭДРЭМЖ, ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛЭХ ЧАДАВХЫГ НЭМЭГДҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ

НҮБ-ын Эдийн засаг нийгэм соёлын эрхийн Хорооны 13-р Зөвлөмжид “Хүртээмжтэй байх асуудлыг үл ялгаварлан гадуурхах, биет хүртээмж, эдийн засгийн хүртээмжтэй байдал” хэмээх 3 хэмжигдэхүүнээр авч үзсэн. Төрөөс боловсролыг хүртээмжтэй байлгах үүрэг нь боловсролын салбарт аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг бүрэн хориглосон эсэх, хүн бүр сурч боловсрох тэгш боломжоор хангагдсан эсэхээр хэмжигддэг. Өөрөөр хэлбэл, хүн бүрд боловсрол эзэмших тэгш боломж байгаа эсэх тухай асуудал юм.

Жендер нь хүмүүсийн хүлээсэн үүрэг, хариуцлага, тулгарч буй саад бэрхшээл, хүртэж буй боломж бололцоог нь дүгнэн шинжлэх нийгэм-эдийн засаг, улс төрийн шинжтэй хувьсах хэмжигдэхүүн бөгөөд нийгмийн анги давхраа, нас, арьс өнгө/яс үндэс, шашин шүтлэг, газарзүй, эдийн засаг, улс төр, соёл, гэр бүлийн орчин гэх мэтчилэн олон үзүүлэлттэй харилцан хамааралтай байдаг. Жендерийн тэгш эрх гэж эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, охид, хөвгүүд, бэлгийн цөөнх хүмүүст тэдний ялгаатай хэрэгцээ, сонирхлынх нь дагуу тэгш шударга хандах явдлыг хэлнэ.

Үндэсний хэмжээнд зайлшгүй авах арга хэмжээнүүдийн санал:

1. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг, ялангуяа боловсролд жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай заалтуудыг анхаарч хэрэгжүүлэх
2. Боловсролын салбарт жендерийн тэгш байдлыг хангах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх
3. Боловсролыг жендерийн мэдрэмжтэй, чанартай болгож, хүртээмжийг нэмэгдүүлэх
4. Боловсролын бүх шатны байгууллагуудыг жендер, нас, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээнд нийцүүлсэн болгох
5. Боловсролын бүх шатны сургалтын хөтөлбөрийг жендерийн мэдрэмжтэй болгох
6. Багш бэлтгэх болон мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийг жендерийн мэдрэмжтэй болгох
7. Боловсролын салбарын бүх байгууллагуудыг бэлгийн дарамт, жендерт суурилсан хүчирхийллээс ангид байлгаж, аюулгүй ажиллах болон сурах орчин бүрдүүлэх
8. Боловсролын салбарын бүх байгууллагууд бэлгийн дарамт, жендерт суурилсан хүчирхийллийн эсрэг бодлого боловсруулж хэрэгжүүлэх
9. Боловсролын салбарт бэлгийн дарамт, жендерт суурилсан хүчирхийлэл гарсан тохиолдолд хариу арга хэмжээ авах журамтай болгох

10. Багшлахуйг жендерийн мэдрэмжтэй болгох
11. Салбарын удирдлага менежментэд жендерийн эрх тэгш байдлыг хангах
12. Салбарын бүх шатны байгууллагуудын менежментэд жендерийн эрх тэгш байдлыг хангах
13. Жендерийн эрх тэгш байдлыг нийгмийн бүхий л хүрээнд нэвтрүүлэхийн тулд боловсролын байгууллагууд бусад салбар, түншүүдтэй хамтран ажиллах
14. Салбарын хяналт шинжилгээ, үнэлгээнд "жендер"-ийн тодорхой үзүүлэлтүүдийг тусгах
15. Сурах бичиг, сургалтын материал стандартад "жендер"-ийн шалгуур үзүүлэлтийг оруулах
16. "Жендер"-ийн хувьд нийцтэй материаллаг орчны үзүүлэлтүүдийг орчны стандартад тусгах
17. ЕБС болон их дээд сургуулийн эрх зүйн баримт бичиг, стратеги төлөвлөлт зэрэг бодлогын баримт бичигт тусгавал зохих жендерийн эрх тэгш байдлыг хангах зүйл, заалтын үлгэрчилсэн загварыг боловсруулан, нэвтрүүлэх
18. Сургуулийн материаллаг орчныг, тухайлбал дотуур байрыг жендерийн хэрэгцээнд нийцтэй болгох
19. Хичээлээс гадуурх үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтэд охид, хөвгүүдийн адил тэгш оролцоог хангах,
20. Охид, хөвгүүдийн жендерийн хэвшмэл ойлголтоор бус мэргэжил сонголтыг дэмжих

ДӨРӨВ. БОЛОВСРОЛЫН ОРЧИНД ХҮҮХЭД БҮР ХАМГААЛАГДАЖ, АЮУЛГҮЙ, ХҮЧИРХИЙЛЭЛГҮЙ ДАРАМТГҮЙ ОРЧИНД СУРАЛЦАХЫН ТӨЛӨӨ

Боловсрол нь нийтийн сайн бөгөөд нийгэм дэх тэгш бус байдлыг арилгахад суурь ач холбогдолтой. Монгол Улс нь сурч боловсрох эрхийн хүрээнд Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Хүүхдийн эрхийн тухай Конвенц, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, ЮНЕСКО-ийн Боловсролын салбарт ялгаварлан гадуурхахын эсрэг конвенц зэрэг заавал мөрдөх ихэнх гэрээг соёрхон баталж, нэгдэн орсон тул Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2, 3-т заасны дагуу эдгээр олон улсын хэм хэмжээ нь үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил мөрдөгдөх учиртай.

- Хүүхдийн эрхийн хорооны Тавдугаар зөвлөмжид “Хорооны зүгээс тус улсад тэгш бус байдал өсөн нэмэгдсээр байгаад, ялангуяа орлого багатай өрхийн, шилжин суурьшсан, бүртгэлгүй, хөгжлийн бэрхшээлтэй, үндэсний цөөнх, өөр хэлтэй, уугуул иргэдийн болон гей, лесбиян, трансжендер (ЛГБТ) гэх мэт эмзэг, хүнд нөхцөлд байгаа хүүхдүүд ялгаварлан гадуурхалтад өртөж буйд, ялангуяа сургууль, дотуур байрны орчинд тэрхүү ялгаварлан гадуурхах үйлдлүүдэд хариуцлага тооцогдохгүй байгаад харамсаж байна.” гэсэн байдаг.
- Сургалтын байгууллагад суралцаж байгаа хүүхэд бүрийг тухайн орчинд бие махбодын шийтгэл, сэтгэл зүйн болон үе тэнгийнхний дарамт, үл хайхрах байдал, гэмт хэрэг, зөрчил, хорт зуршилд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө ажиллах үүрэгтэй ч, удаа дараагийн зөвлөмжөөр өгсөн заалтад ач холбогдол өгч ажиллахгүй байна. Сургалтын орчинд бие махбодын шийтгэл багассан ч багш, насанд хүрэгчдийн зүгээс сэтгэл санааны шийтгэл үзүүлэх, ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл үйлдэх явдал буурахгүй байна.
- Хүүхэд суралцах, боловсрол эзэмшихэд эцэг эхийн дэмжлэг, хайр халамж нэн чухал бөгөөд харамсалтай нь хайр халамж, хоол хүнс, хувцас хунаргүй үл хайхрах хүчирхийлэлд өртөж, хараа хяналтгүйн улмаас сургуульдаа явж чадахгүй, алхам тутамд өлсөх, даарах, ялгаварлагдах бэрхшээлтэй тулгарсны улмаас боловсролоос хөндийрэх тохиолдол нийтлэг байна.

Үндэсний хэмжээнд зайлшгүй авах арга хэмжээнүүдийн санал:

1. Хүүхэд хамгааллын хуулийн хэрэгжилтэд хүүхдийн төлөө ажилладаг мэргэшсэн ТББ, иргэний нийгэмтэй хамтран ажиллах. Швед, БНСУ-ын хүүхэд хамгааллын чиглэлээр ажилласан туршлага нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, эрт илрүүлэг, иргэд олон нийтийн оролцоон дээр хүүхэд хамгааллын чиглэлээр мэргэшсэн ТББ, иргэний нийгэмтэйгээ хамтран ажилласан байдаг.

2. Боловсролын багц хуулийг дагаж гарах дүрэм журмыг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах процесст иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулах
3. Шинээр батлагдсан бодлогын баримт бичгийг олон нийтэд таниулан, сурталчлах, хэрэгжүүлэгч нэгжид нэгдсэн ойлголт өгөх ажлын үр дүнтэй зохион байгуулах
4. Хүүхэд хамгааллын гол асуудалд анхаарах: эрсдэлт хүчин зүйлийг судлах, эрсдэлийг таних, үнэлэх, мэдээлэх, зөвлөх, урьдчилан сэргийлэх ажилд анхаарал хандуулах, хамгаалах хүчин зүйлийг ойлгуулах, дэмжлэг үзүүлэх иргэд, олон нийтийн оролцоо, багш ажилчид, сургуулийн захиргаа, бусад мэргэжлийн байгууллагуудын хамтран ажиллагааг сайжруулах
5. 2024 онд Монгол Улсын Засгийн Газар НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороонд Монголын хүүхдийн аж байдлын тухай 6,7-р тайлан илтгэлээ тавих ба илтгэлтэй холбогдуулан НҮБ-аас өгөх Зөвлөмжийн мөрөөр хийх ажлаа төлөвлөн, жил бүрийн төлөвлөгөө төсөвт тусган хэрэгжүүлэх
6. Боловсролын орчин дахь Үе тэнгийн хүчирхийлэл бол ганц боловсролын асуудал биш, нийгэм, насанд хүрэгчид, эцэг эх, асран хамгаалагчдын буруу үлгэр дуурайлал, нөлөө их байгаад бүх нийтээрээ анхаарал хандуулан ажиллах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд ач холбогдол өгөх, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зүй зохист мэдээллийг түгээх.
7. Төрийн албан хаагчдын хүний эрхийн тухай ойлголт мэдлэгийг дээшлүүлэх
8. Төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоог сайжруулах
9. Орон нутгийн төрийн байгууллагуудыг мэдээллийн нэгдсэн баазтай болгох
10. Сургууль, дотуур байран дахь үе тэнгийн хүчирхийлэл, дарамтаас урьдчилан сэргийлэх, өсвөр насныхны сэтгэцийн эрүүл мэндийн асуудалд анхаарах, сургууль дээрх нийгмийн ажлын үйлчилгээг чанаржуулах, боловсролын ялгаатай хэрэгцээг хангах зэрэг асуудалд боловсролын салбар анхаарах
12. Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын чиглэлээр бүсчилсэн хэлбэрээр хүүхдийн төлөө ажилладаг, мэргэшсэн ТББ-тай гэрээлэн ажиллах хөтөлбөрийг хэрэгжүүлэх
13. Хүүхдийн эрхийн тухай хуульд туссан хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан, Хүүхэд гэр бүл хөгжлийн газрын (ХГБХГ) нийгмийн ажилтан, орон нутгийн ХГБХГ, хэлтсийн нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан, хүүхдийн эрхийн улсын байцаагч гэсэн албан тушаалын ажил үүргийн хуваарийг нарийвчлан гаргаж, давхардсан ажил үүргийг цэгцлэх
15. Үе тэнгийн дээрэлхэлтийг таслан зогсоох аяныг жил бүр 11 сарын эхний долоо хоногт орон нутгийн түвшинд зохион байгуулж хэвших
16. Сургуулийн орчин хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэсэн, хамгаалсан, оролцогч талуудын ардчилсан оролцоотой байх
17. Сургуулийн оролцогч талуудад хуулийг сурталчлах үйл ажиллагаа үр дүнтэй зохион байгуулах, сургуулийн дүрэм журмаа уялдуулахад анхаарах
18. Сургуулийн оролцогч талуудад эерэг хүмүүжлийн талаар ойлголт нэмэгдүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах
19. Багш, сурагчдыг хичээлээс гадуурх үйл ажиллагаа зохион байгуулж харилцан суралцах, хөгжих боломжтой анги танхимтай болгож, бодлогоор дэмжих

ТАВ. НИЙГМИЙН ЭГЭХ ХАРИУЦЛАГАТАЙ БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ТӨЛӨӨ

Монгол улс боловсролыг хөгжлийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлж, төр олон нийтийн оролцоог хангаж, хамтын хариуцлага хүлээх бодлогыг төрөөс баримталж байна.

Төр сурч боловсрох эрхийг хангахад голлох үүрэг гүйцэтгэх ёстой ч боловсролын салбарын өргөн хүрээний зорилтыг биелүүлэхэд оролцогч талуудын уялдаа холбоо бүхий хамтын ажиллагааг бий болгох нь хамгийн чухал. Боловсрол нь бид бүгдийн хамтын үүрэг хариуцлага төдийгүй нийтийн хүчин чармайлтын үр дүнд хөгжиж чанаржина.

Боловсролын салбарт хамтын хариуцлага хүлээх оролцогч талуудыг төр, Засгийн Газар, сургуулийн удирдлага, багш, ажилтан, эцэг эх (асран хамгаалагч), суралцагч, ТББ, олон улсын байгууллага, хувийн хэвшил гэж тодорхойлж байна. Сургууль, боловсрол, сургалтын байгууллага нь албан ёсоор төрийн өмнө, албан бусаар эцэг эх, суралцагчдын өмнө хариуцлага хүлээдэг.

- Сайн засаглалын тухай асуудал нь боловсролын байгууллага тус бүрээр яригдахаас гадна боловсролын тогтолцооны түвшинд ч ярих асуудал мөн билээ. Өнөөдөр боловсролын салбарт гарч байгаа бодлого, шийдвэр оролцоонд хэр тулгуурлаж байна, хэрэгжилтэд хөндлөнгийн мониторинг хийх боломж хэр байгаа зэргээр ардчилсан засаглал энэ салбарт тогтож чадсан эсэхийг хэмжих боломжтой. Гэвч өнөөгийн эрх зүйн зохицуулалт, практикийг шинжилж үзэхэд иргэдийн оролцоо шийдвэр гаргах түвшинд туйлын хангалтгүй байна. Иргэд аливаа шийдвэр гаргах үйл явцад шийдвэр гаргагчдын хүссэн үед биш, өөрсдийн хүсэл зоригоор, сайн дурын үндсэн дээр оролцож, өгсөн санал нь туссан эсэх, тусаагүй бол яагаад гэдэг шалтгаанаа мэдэх боломжтой утга учиртай оролцоог эрх зүйн хүрээнд институтчилэх шаардлагатай байна. Оролцоог хангахдаа нийгмийн бүх бүлэг, тэр дундаа эрх мэдлийн цөөнхийн оролцоог хангах явдлыг чухалчлан үзэх ёстой.
- Бидний бий болгохыг зорьж байгаа боловсролын тогтолцоонд зайлшгүй яригдах асуудал бол сайн засаглал, боловсролын салбарын нийгмийн эгэх хариуцлага юм. Хууль тогтоомжоор ил тод байдал, оролцооны асуудлыг хуульчлан зохицуулсан хэдий ч шийдвэр гаргах үйл явц хаалттай, оролцоонд тулгуурладаггүй, эсвэл ёс төдий оролцоотой байх явдал түгээмэл байгаа тул нийгмийн эгэх хариуцлагын тогтолцоо ажиллахгүй байна.

Үндэсний хэмжээнд зайлшгүй авах арга хэмжээнүүдийн санал:

1. Боловсролын салбарын хариуцлагын тогтолцоо, ил тод байдал сул, эцэг эхийн оролцоо, иргэний нийгмийн байгууллагын оролцооны байнгын механизм хуульчлагдсан ч

- тогтвортой ажиллахгүй, хяналтын механизм төлөвшөөгүй байгаа нөхцөл байдлыг өөрчлөхийн тулд эцэг эх, оролцогч талуудын утга учиртай оролцоог сайжруулах чиглэлд шинэчлэл өөрчлөлт хийх
2. Боловсролын шинэчилсэн багц хуулийг оролцогч талуудад сурталчлах ажлыг үр дүнтэй зохион байгуулах, оролцогч талуудыг сургуулийн дүрэм журам, үйл ажиллагааны талаар тогтмол мэдээллээр хангах, шийдвэр гаргах түвшинд санал, санаачилгыг тусган хэрэгжүүлж тайлагнадаг байх асуудлыг хуулийг дагалдан гарах дүрэм журмуудад тодорхой зааж өгөх
 3. Боловсролын хууль, тогтоомжоос харахад сургууль, цэцэрлэгт эцэг эхийн оролцоог тодорхой хэмжээнд хуульчилсан байх бөгөөд боловсролын яам, аймаг нийслэлийн түвшин дэх иргэд, иргэний нийгмийн оролцоо хуульчлагдаагүй байна. Боловсролын салбарын төлөвлөлт, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хянаж үнэлэх үйл явцад иргэний нийгмийн бодит оролцоог бий болгох орон нутгийн санаачилгыг дэмжих
 4. Боловсролын салбарын төсөв, нөөцийн хуваарилалт нь сургалтын чанарт нөлөөлөх бас нэг чухал хүчин зүйл билээ. Энэ хүрээнд эцэг эхээс төсөвт тусдаггүй зардлуудыг шаардах гэх мэтээр эдийн засгийн боломж муутай эцэг эхэд сургуулийн зүгээс дарамт учруулж, улмаар хүүхдийг ялгаварлан гадуурхах, дарамтлах, сургууль завсардахад хүргэж байгаа нэг шалтгаан болж байгааг анхаарах
 5. Сургуулиудыг гэнэт хаах, хичээл сургалтыг цахим горимд шилжүүлэхээс аль болох зайлсхийх, сургууль нийгэм-эдийн засгийн тэгш бус байдлыг тэгшитгэдэг орон зай бөгөөд гэртээ суралцсанаар хүүхдийн сурлагын амжилтад орон сууцны нөхцөл, гэр бүлийн нөхцөл байдлаас (хангалттай зай талбай, дижитал хэрэгсэлтэй эсэх, эцэг эхийн дэмжлэг, гэх мэт.) шалтгаалахад хүрдгийг ойлгох
 6. БШУЯ иргэний нийгмийн байгууллагатай хамтран орон нутгийн Боловсролын газар, хэлтэс, сургуулийн удирдлагуудыг нийгмийн эгэх хариуцлагын сургалтад заавал хамруулсан байх
 7. Орон нутгийн түвшинд Боловсролтой холбоотой хууль, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулахад олон талын оролцоот хяналт, үнэлгээ хийх эрх мэдэл олгох, боловсрол, сургалтын байгууллагуудын төсвийн хуваарилалтын эрх тэгш байдал, зарцуулалтын хяналтад оролцогч талуудын оролцоог хангаж, хяналт тавих үүргийг ноогдуулах
 8. Багшийг ажилд авахдаа олон талын төлөөллийг хангадаг байхаар журамлах, ил тод, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах. Байгууллагад ажиллаж буй хүний нөөцийн мэдээллийг ил байлгах.
 9. Оролцогч талуудын төлөөллийг ханган сургуулийн түвшинд сайн засаглал буюу эгэх хариуцлагын нөхцөл байдлыг үнэлэх, хянах, сайжруулах ажлыг тогтмолжуулах, үр дүнг тооцож ажиллах
 10. Сургуулийн захиргаа үйл ажиллагаа, төсөв, санхүүжилт, түүний зарцуулалтын талаар болон нэмэлт орлогын (заал түрээс, хандив, төсөл, шагнал) талаарх мэдээллээ олон нийтэд ойлгомжтойгоор, ил тод, тодорхой хугацаанд тайлагнадаг байх

**БОЛОВСРОЛЫГ БҮХ НИЙТЭД!
БҮХ НИЙТ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨӨ!**



“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн ТУНХАГ

Боловсрол нь хүн бүрийн өдөр тутмын амьдралд, насан турш нөлөөлөх үндсэн эрх, хүний хөгжлийн түлхүүр бөгөөд иргэн бүрт чанартай боловсрол олгох нь төрийн хүлээх гол үүрэг хариуцлага гэдэгт итгэн;

Өнөөгийн тогтолцоонд боловсролыг явцуу тодорхойлдог, хүн бүрийн ялгаатай байдлыг харгалздаггүй, ялгаварлан гадуурхдаг, хангалттай санхүүжилт олгодоггүй зэргээс шалтгаалан бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх үйл явцад цогц хандлага дутагдаж; боловсролын тогтолцооны үр өгөөж нь хувь хүний хүсэл тэмүүлэл, нийгмийн эрэлт хэрэгцээнээс асар зөрүүтэй байсаар ирсний улмаас үнэ цэнэтэй амьдарч, амьдралын чанараа дээшлүүлэх боломж олгохгүй байгаад сэтгэл зовнин;

Энэ нь эрх мэдлийн шударга бус бүтцийг бий болгож, тэгш бус байдлыг хадгалж үлдэх арга зам болж байгааг эсэргүүцэн;

Боловсролын чанар, хүртээмж, хариуцлагатай байдлын төлөө хүчээ нэгтгэн ажиллаж, энэ үйл явцад хувь хүн, иргэний нийгмийн байгууллага, бүлгүүдийг өргөнөөр татан оролцуулж, өргөн суурьтай, зохион байгуулалттай, хүчтэй хөдөлгөөн бий болгохыг чухалчлан;

Энэ үйл явцад нийгмийн бүх бүлэг, ялангуяа эрх мэдлийн цөөнхийн оролцоог хангахыг онцлон;

Иргэд, бүлгүүдийн мэдлэг, чадварыг хөгжүүлж, тулгарсан асуудлаа гаргаж ирэх, шийдлийг шаардах, хариуцлага тооцох чадавхтай болоход нь дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэн;

Боловсролын тогтолцоог хүний мэдэх, бүтээх, хүний ёсоор хамтран амьдарч, нэр төртэйгээр оршиход суралцахуйц, хувь хүний потенциал, чадвар, чадавхыг нээж, эерэг зан үйл, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн, хүмүүнлэг, ардчилсан, хүн бүрийн эрхийг хангасан, тэгш хүртээмжтэй болгон өөрчлөхийг эрхэмлэн;

Хүүхэд, эцэг эх, багш, орон нутгийн бүлгүүд болон үндэсний, хэлний, соёлын, бэлгийн цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, орлого багатай иргэд зэрэг дуу хоолойгоо хүргэж, шийдвэр гаргахад оролцож чадахгүй байгаа бүлгүүдийг эрх мэдэлжүүлэх зорилгоор боловсролын тогтолцоо, бодлогод хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чадавхыг бүрдүүлэх, нөлөөлөх ур чадвараа дээшлүүлэх шаардлагыг ухамсарлан;

Хүний эрх, жендэрийн тэгш эрх, үл ялгаварлан гадуурхах, хүчирхийллээс ангид, хүлээцтэй байх, нээлттэй, ил тод, хариуцлагатай байх зарчмыг баримтлан;

Монгол улсад боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийг хянах, хариуцлага шаардах, бодлогод нөлөөлөх үндэсний кампанит ажил зохион байгуулах зорилгоор эвсэн нэгдсэнээ тунхаглаж байна.

2010 оны 9 сарын 3

UIH.MN
СУДАЛГААНЫ САН